



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
 ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/132

Шивээговь сум

Газар эзэмших эрхийг шилжүүлэх  
 тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 30 дугаар зүйлийн 30.1, 38 дугаар зүйлийн 38.4, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаал “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 5.4.2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:


1.Ахар овогт Дамбасүрэнгийн Оюунчимэг /ЗЛ63090901/ нь Шивээговь сумын 2 дугаар баг, Бэхтийн булгийн зүүн хойд талд “Өвөлжөө, хаваржаа”-ны зориулалттай 700м<sup>2</sup> газрын газар эзэмших эрхийг шилжүүлэх хүсэлт гаргасан тул иргэн Амардалай овогт Энхтөрийн Байгалмаа /ЗП84040948/-д Шивээговь сумын 2 дугаар баг, Бэхтийн булгийн зүүн хойд талд байрлах 700м<sup>2</sup> газрыг “Өвөлжөө, хаваржаа”-ны зориулалтаар эзэмших эрхийг анх авсан этгээдийн үлдсэн хугацаагаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Монгол Улсын Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулийг дагаж мөрдөхийг газар эзэмших эрхийг шилжүүлэн авч буй иргэн (Э.Байгалмаа)-д үүрэг болгосугай.

3.Газар эзэмших эрхийг шилжүүлэн авч буй иргэн Э.Байгалмаатай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг сумын Газрын даамал (Т.Өлзийбуд)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/43 дугаар захирамжийн 3 дахь бүртгэлийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА